



Оюутны гадаад үгийн хэрэглээнд хийсэн харьцуулсан дүн шинжилгээ (МУБИС ба УБЭИС-ийн жишээн дээр)

Төрбат Батболд^{1*}, Цэрэндорж Жигмэд²

¹Монгол улс, Улаанбаатар, Монгол Улсын Боловсролын Их Сургууль,

Математик Байгалийн Ухааны сургууль, Мэдээлэл зүйн тэнхим

²Монгол улс, Улаанбаатар, Улаанбаатар Эрдэм Их сургууль, Нийгмийн ухааны сургууль

*Холбоо барих зохиогч: batbold.t@msue.edu.mn

Хүлээн авсан: 2021.03.23

Засварласан: 2021.12.27

Хэвлэлтэд авсан: 2022.01.15

Хураангуй

Чөлөөт нийгмийн хөгжил, даяаршил боловсролын салбарт нөлөөлж байгаагийн нэг илрэл нь оюутны бичгийн болон аман ярианд хэрэглэгдэж байгаа гадаад үгийн байдлаас ямар нэг хэмжээгээр харагддаг. Яриа болон бичгийн хэлэндээ гадаад үг ихээр хэрэглэх нь монгол хэлний дархлаанд муугаар нөлөөлж монгол хэл устах аюултай эсвэл тухайн хэлний үгийн сан баяжин тэлэх сайн талтай гэсэн үзэл хандлагууд байгаа нь судлах чухал асуудлын нэг юм. Дэлхийн олон хэлний мөхлийн шалтгааныг судалсан эрдэмтэн Дэвид Кристал үзэхдээ “тухайн хэлээр ярьдаг хүнгүй буюу үндэстэнгүй болбол хэл гарцаагүй мөхнө” хэмээн баталсан байдаг. Эндээс дүгнэлт хийж үзвэл тухайн хэлээр ярихгүй болбол хэл мөхдөг ярих хүн олширвол хэл хөгжиж байна хэмээн үзэж болох нь. Бид МУБИС-ийн Багшийн сургууль болон УБЭИС-ийн Нийгмийн ухааны сургуулийн 250 оюутнаас судалгааг авч тэдний хэрэглэж байгаа гадаад үгийг шинжлэх ухааны болон ахуйн хэрэглээний гэсэн 2 бүлэг асуудлын хүрээнд 10 шалгуур үзүүлэлтээр асуулга, ярилцлага, эх материалд дүн шинжилгээ хийх аргыг ашиглан судаллаа. Судалгаагаар оюутны 48% нь англи хэл хэрэглэдэг, 54% нь хоёр хэлийг хольж ярьдаг, 28% нь гадаад үг ашиглах нь буруу гэж үздэг, 42% нь харилцах зорилготой гадаад үгийг ашигладаг, 38% нь гадаад үгийг яриандаа тодорхой бодолгүйгээр, 46% нь бичгийн хэлэнд шинжлэх ухааны гадаад үгийг хэрэглэж байгаа нь харагдаж байна. Судалгааны үр дүн оюутнууд гадаад үгийг яриандаа ихээхэн хэрэглэж байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь эх хэлний цэвэр байдлаа хадгалах, монгол хэл, бичиг үсгийг эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах, төрөлх хэлний дархлааны асуудлыг анхаарахын хамтаар боловсролын үе шат бүрд болон сургалтын бүхий л үйл ажиллагаанд анхаарах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Түлхүүр үг

Яриа болон бичиг хэл, хэлний соёл, даяаршил, хэрэглээ



Удиртгал

Дэлхий, ялангуяа боловсролын олон асуудал даяаршлын нөлөөнд хүчтэй автаж байгаа цаг үед гадаад хэлийг сурах нь хүн бүрийн болон оюутанд нэн тэргүүнд хамаарах асуудал юм. Хүмүүс гадаад хэлийг сайн сурах нь хүсэл мөрөөдөлдөө хүрэх, шийдвэр гаргах чадвар нь сайжрах, ажлын бүтээмж, үр ашиг, үр нөлөө нь дээшлэх, аливаа эрсдэлийг даван туулах, ажлаа хөнгөвчлөх, эрүүл мэндээ хамгаалах, стресс багасгах олон талын тустай. Гадаад хэлийг амжилттай сурах нь хүн өөрийгөө зөв удирдахтай холбоотой юм. Тэр ч утгаараа гадаад хэлийг эзэмших, гадаад үгийг яриандаа хэрэглэх гэсэн асуудлыг зөв ойлгох хэрэгтэй юм. Үүнийг ялгаж чадсан хүн гадаад хэлийг үр ашигтай сурна. Хүмүүс албан ажил, гэр орон, олон нийтийн газарт үйл ажиллагааны явцад гадаад үгийг ухамсаргүйгээр хэрэглэж, эх хэлнийхээ яруу тансаг байдлыг үгүй хийхэд хүргэдэг олон хүчин зүйлс байдаг. Харин хүмүүс хэл сурах, гадаад үгийг яриандаа болон бичихдээ хэрэглэхэд хүргэж буй хүчин зүйлсийг мэдэж байж соёлтой, боловсролтой иргэн болж төлөвших юм (Ekaterina Koneva, 2014, p.322).

Нэрт орчуулагч, эрдэмтэн Г.Аким “Гадаад үг нэвтрэхийг хязгаарлах хэрэгтэй гэсэн маань гадаад үгийг огт хэрэглэхгүй байх хэрэгтэй гэсэн үг огт бус аа. Олон улсын харилцаа өргөжиж мэдээлэл солилцох нь ихсэж байгаа одоо үед гадаад нэр томьёо хэлэнд нэвтрэх зүй ёсны үйл явцыг хэн ч зогсоож чадахгүй юм. Гадаад үгийг авахад авна. Харин яаж авах вэ? Бичлэгээр нь авах уу, эсвэл өөрийн авианы зүйд нийцүүлэн авах уу? хэмээн өөрийн судалгааны бүтээлдээ дурдсан байдаг.

Түүнчлэн эрдэмтдийн бичсэнээс үзэхэд, харь үгийг тухайн хэлний авианы хууль, үгийн бүтцийн ерөнхий жам ёсонд нийцүүлэн нутагшуулаад, хэвшүүлчихдэг арга (Б.Пүрэв-Очир) аль ч хэлэнд байдаг, угаас хэлний өөрийгөө хамгаалах тогтолцоотой (М.Саруул-Эрдэнэ) холбоотой үзэгдэл болох нь тодорхой байна (М.Саруул-Эрдэнэ, 2006, х.26-29).

Эх хэлний талаарх мэдээлэлд олон нийт сонор соргог байгаагийн шалтгаан нь эргэн тойрон харагдах эрэн мяраан хаяг, сурталчилгаанаас эхлээд гар утас, компьютерт хэрэглэх харь үг, улмаар гадаад үг холин хэлэлцэх хүүхэд залуус, тэр ч байтугай сэтгүүлч, улс төрчдийн үг хэлнээс ч гарч байгаа нь эмээглэл юм.

Бид монголоор ярихаас илүү чамирахаж яриандаа гадаад үг хавчуулан, эсвэл хүүхдэдээ зааж байна гэж гадаад хэлээр ярьж, шинэ үетэйгээ хөл нийлүүлж байна гээд гадаад үгийг ашиглаж байгаагаас харж болох юм.

Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн ЭШАА, доктор (Ph.D) Г.Гэрэлмаа “Монгол хэл мөхөж байгаа юу!?” өгүүлэлдээ даяарших үйл явц, олон соёлын нөлөөллийн дор оршин байгаа бидний монгол хэл мөхөх аюултай юу гэвэл, аюултай, гэвч мөхлөөс холуур авч гарах, хөгжүүлэхийн тулд монгол хүн бүр сэтгэлээ чилээж, хэлний бодлогод захирагдах нь чухал юм. Үүнтэй уялдуулан тэмдэглэхэд, ЮНЕСКО-оос энэ жилийн “эх хэлний өдөр”-ийг “Дэлхийн иргэншилд хүргэх эх хэл: Шинжлэх ухаан бүгдийн анхааралд” гэсэн уриатай гаргаж, түүндээ “Эх хэл бол орчин цагийн математик, физик, технологи гэх мэт шинжлэх ухааны мэдлэгийг бүхэлд нь бүрэн төгс дамжуулж чадах үгийн арвин их баялаг юм” хэмээсэн нь техник технологийн үг хэллэг болгоныг англи үгээр аваад байх гэсэн санаа биш юм хэмээсэн байна.

Хүн гадаад хэл сурах, гадаад үгийг хэрэглэхдээ юуны өмнө бүх үйлдлээ ухамсарлан ажиллавал үр дүнд хүрнэ. Иймээс оюутны гадаад үгийг хэрэглэж буй байдлыг судлан тогтоож сурган хүмүүжүүлэх ажилд ашиглах нь зүйтэй юм.


Судалгааны арга зүй

Судалгааг 2 бүлэг асуудлын хүрээнд асуулгын аргаар 10 асуулга боловсруулж онлайн-аар авсан. Асуулгыг Google Form технологийг ашиглан авч, статистик боловсруулалт хийж, үр дүнг танилцуулав.

Үр дүн

Figure 1

Number of Participants of the Study



Судалгаанд:

МУБИС-ийн Багшийн сургуулийн Бага ангийн багш мэргэжлээр суралцаж байгаа 150 оюутан, УБЭИС-иас Нийгмийн ухааны сургуулийн Сургуулийн өмнөх боловсрол, бага боловсролын багш, эрх зүйч, англи хэлний багш мэргэжлээр суралцаж байгаа 100 оюутан нийт 250 оюутнаас судалгааг авч харьцуулсан дүгнэлт хийлээ.

Гадаад үгийг яриандаа хэрэглэж байгаа талаар

Table 1

The Use of Foreign Words by Languages /percentage/

Сургуулийн ангилал	Англи	Орос	Солонгос	Хятад	Бусад
МУБИС-ийн БС	85.9	6.4	7.7	-	-
УБЭИС-ийн НХУС	48	14	-	-	38
Зөрөө	37.9	7.6	7.7	-	38
Дундаж	66.9	10.2	3.8	-	19

Хүснэгтээс харахад:

Оюутнууд яриандаа англи үг ихэвчлэн хэрэглэдэг (66.6%) нь судалгаагаар харагдаж байна. Үүнийг англи хэлийг төрийн бодлогоор дэмжиж байгаатай холбоотой гэж үзэж болно.

УБЭИС-ийн оюутнуудын 38% бусад өөр гадаад хэлийг хэрэглэдэг, 14% нь орос үг хэрэглэдэг гэсэн нь тухайн сургуульд олон гадаад хэл үздэг, мөн орос оюутнууд суралцдагтай холбож үзэж болох юм.

Table 2
The Use of Foreign Words in Daily Speech /percentage/

Сургуулийн ангилал	Их	Дунд зэрэг	Бага	Хэрэглэдэггүй
МУБИС-ийн БС	-	23	74.4	2.6
УБЭИС-ийн НХУС	-	28	66	6
Зөрөө	-	5	8.4	3.4
Дундаж	-	25.5	70.2	4.3

Судалгаагаар :

- Оюутнуудын дунджаар 70.2% нь яриандаа гадаад үгийг бага хэрэглэдэг гэж дүн гарсан нь эх хэлээ хамгаалах талаас нь харвал боломжийн үзүүлэлт юм. Тухайлбал, МУБИС-ийн БС -ийн оюутны 74.4% бага хэрэглэдэг байна.
- Гэхдээ МУБИС-ийн БС ба УБЭИС-ийн НХУС-ийн оюутнуудын 95.7% өдөр бүр яриандаа гадаад үг хэрэглэдэг гэж дүгнэж болохоор байна.

Table 3
Frequency of Using Foreign Words /percentage/

Сургуулийн ангилал	2 хэл	3 хэл	3-аас дээш
МУБИС-ийн БС	96.2	3.8	-
УБЭИС-ийн НХУС	74	18	8
Зөрөө	22.2	14.2	8
Дундаж	85.1	10.9	4

- Оюутнуудын 85.1% нь яриандаа хоёр гадаад хэлний үгийг зэрэгцүүлэн хэрэглэж ярьж байгаа нь сайн үзүүлэлт биш юм. Тухайлбал, МУБИС-ийн БС-ийн оюутны 96.2%, УБЭИС -ийн НХУС-ийн оюутны 74 % нь яриандаа хоёр гадаад хэлийг зэрэгцүүлэн хэрэглэж ярьж байгаа нь хэлний соёл талаасаа болон бага ангийн болон сургуулийн өмнөх насны хүүхдийн багш болох оюутанд ирээдүйн мэргэжилд муу нөлөө үзүүлж болох талтай.

Table 4
Attitude Towards Using Foreign Words /percentage/

Сургуулийн ангилал	Зөв	Буруу	Гарцаагүй учраас	Хэлний ядууралд орж байгаа учраас	Бусад
МУБИС-ийн БС	38.8	37.2	24	-	-
УБЭИС-ийн НХУС	34	40	14	6	6
Зөрөө	4.8	2.8	10	6	6
Дундаж	36.4	38.6	19	3	3

- Оюутнууд гадаад үгийг яриандаа хэрэглэх нь зөв, буруу гэсэн хандлага үндсэндээ ойролцоо байна. МУБИС-ийн БС-ийн оюутнуудын хувьд 24 % нь гарцаагүй байдлаар гадаад үгийг яриандаа хэрэглэх болдог гэсэн ба УБЭИС-ийн НХУС-ийн судалгаанд хамрагдсан оюутнуудын ойлголтын зөрүү (10 %) байгаа сонирхолтой үр дүн гарлаа.
- Харьцуулсан судалгаанаас дүгнэхэд МУБИС-ийн БС ба УБЭИС-ийн НХУС-ийн судалгаанд хамрагдсан оюутнуудын хувьд хэлний ядууралд орж байгаа учраас гадаад үг ашиглаж байна гэсэн ойлголт бага байгааг харж болно.

- Харин гарцаагүй байдлаар гадаад үгийг яриандаа хэрэглэх ёстой гэсэн хандлага их (19 %) хувьтай байгаа нь сонирхолтой байна.

Table 5

Explanation for Using Foreign Words in Speech /percentage/

Сургуулийн ангилал	Даяаршил	Монгол үг мэдэхгүй	Эмзэглэдэг	Чамирхдаг	Бусад
МУБИС-ийн БС	41	14.1	-	6.4	38.5
УБЭИС-ийн НХУС	46	36	-	14	4
Зөрөө	5	21.9	-	7.6	34.5
Дундаж	43.5	25.1	-	10.2	21.2

- Оюутны бараг 50% нь даяаршиж байгаа учраас гадаад үг яриандаа хэрэглэх хэрэгтэй гэж үзжээ. Энэ талаар дээрх 2 сургуулийн оюутнууд ойролцоо бодолтой байна.

- Монгол үгээ мэдэхгүй гадаад үг яриандаа хэрэглэдэг оюутан 25.1%, чамирхаж гадаад үг яриандаа хэрэглэдэг оюутан 10.2% байгаа хэлний дархлаанд эрсдэлд орох магадлалтай юм.

Table 6

Frequently Used Foreign Words by Areas /percentage/

Сургуулийн ангилал	Спорт	Урлаг	Шинжлэх ухаан	Ахуйн хэрэглээ	Бусад
МУБИС-ийн БС	-	-	7.7	71.8	20.5
УБЭИС-ийн НХУС	2	2	12	70	14
Зөрөө	2	2	4.3	1.8	6.5
Дундаж	1	1	9.8	70.9	17.3

- Оюутнууд үндсэндээ ахуйн чанартай гадаад үг (70.9%) яриандаа хэрэглэж байна. Тухайлбал, МУБИС-ийн БС-ийн оюутны 71.7 % нь, УБЭИС-ийн НХУС -ийн оюутны 70% нь гадаад үг яриандаа хэрэглэдэг.

- Харьцуулсан судалгаанаас үзэхэд сургуулиудын оюутан шинжлэх ухааны чиглэлтэй гадаад үг яриандаа хэрэглэх нь арван хувь хүрэхгүй байгаа бөгөөд судалгааны асуумжаас өөр чиглэлээр хэрэглэдэг гадаад үгийн зөрөө харьцангуй их байна.

Table 7

Students' Opinion About the Use of Foreign Words /percentage/

Асуулга	МУБИС-ийн БС	УБЭИС-ийн НХУС	Зөрөө	Дундаж
Гадаадад нээлттэй болж байна	17.9	18	0.1	18
Эх хэл баяжигдаж байна	12.8	16	3.2	14.4
Гадаад хэл сурахад тустай	60.3	38	22.3	49.1
Зайлшгүй байх ёстой зүйл	9	14	5	11.5
Бусад	-	14	14	7

Судалгааны үр дүнг эрэмбэлэхэд:

- “Гадаад хэл сурахад хэрэгтэй тул” яриандаа гадаад үг хэрэглэх хэрэгтэй (49.1%) гэж үздэг бөгөөд ялангуяа МУБИС-ийн БС -ийн оюутны 60.3% нь ийм бодолтой УБЭИС-ийн НХУС -ийн оюутнаас эрс ялгаатай байна.

- “Нийгэм нээлттэй болж байгаа учраас” яриандаа гадаад үг хэрэглэх хэрэгтэй (18%)
- “Эх хэл баяжиж байдаг тул” яриандаа гадаад үг хэрэглэх хэрэгтэй (14.4%)
- “Зайлшгүй байх ёстой зүйл учраас” яриандаа гадаад үг хэрэглэх хэрэгтэй (11.5%) тус тус үзжээ.

Table 8

Awareness of Using Foreign Words /percentage/

Асуулга	МУБИС-ийн БС	УБЭИС-ийн НХУС	Зөрөө	Дундаж
Ухамсартай хэрэглэдэг	69.2	44	25.2	56.6
Бодлогогүй хэрэглэдэг	23.1	48	24.9	35.5
Янз бүр байдаг	7.7	8	0.3	7.8

Судалгаагаар:

- Яриандаа гадаад үг “Ухамсартай хэрэглэдэг” гэж МУБИС-ийн БС -ийн оюутны 69.1%, УБЭИС-ийн НХУС-ийн оюутны 44% нь үзэж байгаа нь эрс ялгаатай (25.2%) байна.
- Яриандаа гадаад үг “Бодлогогүй хэрэглэдэг” гэж УБЭИС-ийн НХУС-ийн оюутны 48%, төрийн өмчийн сургуулийн оюутны 23.1% нь үзэж байгаа нь зөрүүтэй (24.9%) байна.
- Энэ судалгаагаар МУБИС-ийн БС-ийн УБЭИС-ийн НХУС-ийн оюутны гадаад үг яриандаа хэрэглэж байгаагаа ухамсарласан байдал эрс тэс өөр байгаа сонирхолтой баримт тогтоогдлоо.

Бичгийн хэлэнд гадаад үг хэрэглэж байгаа байдал

Table 9

The Use of Foreign Words in Writing /percentage/

Сургуулийн ангилал	Англи	Орос	Солонгос	Хятад	Бусад
МУБИС-ийн БС	88	-	12	-	-
УБЭИС-ийн НХУС	72	2	12	6	8
Зөрөө	16	2	0	6	8
Дундаж	80	1	12	3	4

Хүснэгтээс харахад:

- Оюутнууд бичихдээ англи үг ихэвчлэн хэрэглэдэг (80%) нь судалгаагаар харагдаж байна. Энэ нь англи хэлийг яриандаа болон бичихдээ их хэрэглэж байгааг харуулж байна.
- Хувийн сургуулийн оюутнууд бичихдээ орос, солонгос, хятад хэлний үг хэрэглэдэг байдал нь улсын сургуулийн оюутнаас ялгаатай байна.

Table 10

The Frequency of Using Foreign Words in Writing /percentage/

Сургуулийн ангилал	Их	Дунд зэрэг	Бага	Хэрэглэдэггүй
МУБИС-ийн БС	-	26	74	-
УБЭИС-ийн НХУС	4	34	52	10
Зөрөө	4	8	22	10
Дундаж	2	30	63	5

- Оюутнуудын 63% бичихдээ гадаад үгийг бага хэрэглэдэг гэж судалгааны дүн гарлаа. Тухайлбал, МУБИС-ийн БС -ийн оюутны 74 % бага хэрэглэдэг байна.
- Дээрх 2 сургуулийн оюутнуудын 93% нь бичгийн яриа буюу бичихдээ гадаад үгийг ихээхэн хэрэглэж байна.

Table 11
Cronbach's Alpha Per Question

	Зүйл-Нийт үзүүлэлт				
	Шугам нь зүйл устсаныг илэрхийлнэ	Хэмжүүрийн утга хэрэв зүйл устгасан бол	залруулсан зүйл-нийт корреляци	Олон корреляцийн талбай	Хэрэв зүйл устгасан бол Кронбахын Альфа
Ямар орны хэлийг яриандаа ихэвчлэн хэрэглэдэг	19.48	33.223	.684	.739	.867
Гадаад үгийг яриандаа хэрэглэдэг хэмжээ	19.33	38.624	.707	.741	.874
Гадаад хэл хольж ярих талаар	19.74	40.049	.414	.690	.884
Яриандаа гадаад үг хэрэглэж байгааг үзэх хандлага	19.17	32.424	.928	.890	.848
Яриандаа гадаад үг хэрэглэж байгааг тайлбарласан байдал	18.63	30.323	.552	.756	.899
Ямар салбарын үг яриандаа их хэрэглэдэг талаар	17.08	38.625	.555	.414	.878
Гадаад үг яриандаа хэрэглэж буй талаар оюутны бодол	18.37	31.897	.874	.883	.850
Оюутны гадаад үг яриандаа хэрэглэж байгаагаа ухамсарласан байдал	19.63	39.849	.357	.348	.887
Ямар орны хэлийг бичихдээ ихэвчлэн хэрэглэдэг	19.68	33.111	.783	.812	.858
Гадаад үгийг бичихдээ хэрэглэдэг хэмжээ	19.01	36.546	.700	.830	.868

Table 12
Cronbach's Alpha Reliability

Найдвартай байдлын үзүүлэлт		
Кронбахын Альфа	Стандартчилгдсан зүйл дээр суурилсан Кронбахын Альфа	N зүйл
.883	.901	10

Найдвартай байдлын шинжилгээ хийхэд Cronbach's Alpha 0.88 гарч байгаа нь судалгааны асуулгын дотоод зохицол найдвартай гэдгийг илэрхийлж байна.

Дүгнэлт

Дээрх 2 сургуулийн оюутнууд англи хэлний үгийг яриа болон бичгийн хэлэндээ ихэвчлэн хэрэглэж байгаа нь англи хэлийг чухалчлан үзэж байгаа төрийн бодлоготой уялдаж байгаа ч эх хэлний дархлаа талаасаа нь авч үзвэл оюутанд зөвлөн тусалж, гадаад үгийг зөв хэрэглэх талаар зааж өгөх шаардлагатайг харуулж байна.

- Мөн оюутнуудын дунджаар 85.1% нь яриандаа хоёр хэлний үгийг зэрэгцүүлэн ярьж байгаа нь харьцангуй их үзүүлэлт бөгөөд хэлний соёл талаасаа болон монгол хэл, монгол соёлоо уламжлан хөгжүүлэхэд муу нөлөө үзүүлж болох талтайд анхаарал хандуулах шаардлага байна.

- Судалгаанд хамрагдсан оюутнуудын гадаад хэлийг яриандаа хэрэглэх талаарх ойлголт ойролцоо боловч гадаад үгийн яриа ба бичгийн хэрэглээг “даяаршиж байгаа учраас”, “гарцаагүй гадаад үг яриандаа хэрэглэх ёстой” гэж зөвтгөсөн хандлага их байгааг анхаарах шаардлага байна.

- Төрийн ба төрийн бус өмчийн сургуулийн оюутны гадаад үг яриандаа хэрэглэхдээ “Ухамсартай хэрэглэдэг” талаар ойлголтын ихээхэн зөрөөтэй байгаа, монгол үгийг мэдэхгүй байгаагаас гадаад үг хэрэглэдэг, чамирхаж гадаад үгийг ярих, бичихдээ хэрэглэдэг гэсэн асуудлуудыг цаашид ч нарийвчлан судалж тодорхой ажлууд зохион байгуулах шаардлагатай юм.

Ашигласан бүтээлийн жагсаалт

Ekaterina V. Konev. (2014). The role of Comparative Analysis in foreign language learning (German and Russian Languages). *Procedia - Social and Behavioral Sciences*. Volume 154, Pages 1-538 (28 October 2014). DOI: 10.1016/j.sbspro.2014.10.156

Саруул-Эрдэнэ, М. (2006). *Эх хэлний өөрийгөө хамгаалах тогтолцоо, сонирхолтой хэл шинжлэл*, Блүүмингтон, 26-29 тал

David Lesliea. HilaryRussell. (2006). The importance of foreign language skills in the tourism sector: A comparative study of student perceptions in the UK and continental Europe *Tourism Management* Volume 27, Issue 6, December 2006, Pages 1397-1407

Heidi Huytinen. TarjaTuononen. Anne Nevgi Auli Toom (2022).

The first-year students' motives for attending university studies and study-related burnout in relation to academic achievement *Learning and Individual Differences* Volume 97, July 2022, 102165

Study on Students' Use of Foreign Words

Batbold Turbat^{1*}, Jigmed Tserendorj²

¹Department of Informatics, School of Mathematics and Natural Sciences, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

²Department of Social Sciences, Ulaanbaatar Erdem University, Ulaanbaatar, Mongolia

*Corresponding author: batbold.t@msue.edu.mn

Received: 3/23/2021/

Revised: 12/27/2021

Accepted: 1/15/2022

Abstract

The influence of the development of a free society and globalization in the field of education is to some extent manifested by the use of foreign words in the students' written and verbal expressions. The presence of different points of view that widespread use of foreign words may adversely affect the immunity of the Mongolian language leading to its destruction or have a positive influence enriching its vocabulary is one of the important issues of consideration. We have conducted the research on the use of foreign words in the academic and informal situations of a total of 250 students of the Teacher's School of the Mongolian National University of Education and the School of Social Sciences of Ulaanbaatar Erdem University using questionnaires, interviews and document analyses based on 20 indicators. The survey results show that 48% of students use English words and expressions frequently, 54% speak mixing languages, 28% find it inappropriate to use foreign words and expressions, 42% use communicative words in their speech, 38% use foreign words spontaneously, and 46% use scientific words or expressions in their writing. As the results of the study indicate that a great majority of students use foreign words and expressions, we have come into conclusion that it is necessary to support students' awareness and efforts in preserving and protecting the purity of the native language, assist them in learning, using and developing the Mongolian language in every learning activities of all the stages of the Education sector.

Keywords

Spoken and written language, language culture globalization, consumption
